



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 0/680

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.1.23-д батлагдсан “Багийн хөгжил, төрийн үйлчилгээ төсөл”-д батлагдсан 300.0 сая төгрөгөөс санхүүжигдэх Уянга сумын Шуранга багийн засвар 8 000 000 (найман сая) төгрөг, Өлт багийн засвар 8 000 000 (найман сая) төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг дээрх сумын Засаг дарга (Б.Доржтогоо)-д шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулахыг сумын Засаг дарга (Б.Доржтогоо)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД

011101283